



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 06 өдөр

Дугаар А/172

Булган сум

Хөгжимт жүжгийн театрын дуучин
Б.Гантөмөрийн уран бүтээлийн тоглолтод
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт” хөтөлбөрийг батлах тухай IV/25 дугаар тогтоол, 2025 оны XII хуралдааны “Булган аймгийн 2026 оны төсөв батлах тухай” XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2026 оны 03 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулагдах Хөгжимт жүжгийн театрын дуучин Б.Гантөмөрийн “Бурхад чуулсан өдөр” бие даасан тоглолтын зохион байгуулалтын зардалд 3,000,000 (гурван сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын “Бүх нийтийн соёлын боловсролыг хөгжүүлэх” хөтөлбөр, төлөвлөгөөг хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.ПҮРЭВ-ОЧИР



6326010223